



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

*“Орон нутгийн хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл”-д
хийсэн нийцлийн аудитын тайлан*



**Сонгуулийн зарим зардлыг анхан шатны баримтгүй зарцуулсан
байна**

Улаанбаатар хот

2017 он



АГУУЛГА

<p>Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Нийцлийн аудитын газар</p> <p><i>Нийцлийн аудитын газрын дарга</i> <i>Б.Алтанзул</i></p> <p><i>Менежер</i> <i>Х.Болдбаатар</i></p> <p><i>Ахлах аудитор</i> <i>Ш.Энхтайван</i></p> <p><i>Аудитор</i> <i>Д.Дорждулам</i></p>	Товчилсон үгийн жагсаалт	3
	Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	4
	Ерөнхий мэдээлэл.....	5
	Бүлэг 1. Сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу хуваарилан зарцуулсан байна.....	6-9
	Бүлэг 2. Хөрөнгийн зарцуулалтад тавьж буй хяналт хангалтгүйгээс анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, зардал хооронд шилжүүлсэн зөрчил гаргасан байна.....	10-11
	Холбогдох байгууллагын санал.....	12
	Дүгнэлт.....	13
	Зөвлөмж.....	13
	Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал.....	14
	Хавсралт №1.....	15
Хавсралт №2.....	16	
Хавсралт №3.....	17	
<p>2017 оны 2 дугаар сар Тайланг ҮАГ-ын веб сайт-аас үзнэ үү. www.audit.mn</p> <p><i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729 дугаарын утас, 260949 дугаарын факсаар харилцана уу.</i></p> <p>Хаяг: <i>Үндэсний аудитын газар</i> <i>Засгийн газрын 4 дүгээр байр,</i> <i>Бага тойруу-3,</i> <i>Чингэлтэй дүүрэг,</i> <i>Улаанбаатар 15160,</i> <i>Монгол улс</i></p>		



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НАГ	Нийцлийн аудитын газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНС	Орон нутгийн сонгууль
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар



Аудит хийх үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, МУЕА-т Үндэсний аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө болон Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь заалтыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Сум, дүүргийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтыг шалгаж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд хийв. Үүнд:

- Сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан эсэх,
- Хөрөнгийн зарцуулалтад тавьж буй хяналт үр дүнтэй эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад Сонгуулийн Ерөнхий хороо, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн тойргийн хороодыг хамруулав.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийх, зорилт арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрчлэн шалгах, судалгаа авах, мэдээллийн эх үүсвэртэй тулган шалгах, сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх зэрэг арга зүйг ашиглалаа.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.



Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Сонгуулийн тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн дагуу сум, дүүргийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийг 10 дугаар сарын 19-ний өдөр Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан байна.

Сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3¹-т сум, дүүргийн сонгуулийн удирдлага, зохион байгуулалтыг сум, дүүргийн сонгуулийн хороо бие даан хэрэгжүүлэх, 31 дүгээр зүйлийн 31.6², 33 дугаар зүйлийн 33.4³-т аймаг, нийслэлийн сонгуулийн хороо сум, дүүргийн сонгуулийн хороог байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахаар хуульчилсан байна.

УИХ-аас 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдөр “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” 06 дугаар тогтоол, “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” 28 дугаар тогтоолыг тус тус баталжээ.

Мөн Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1⁴, 38.2⁵ дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн “Сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” 27 дугаар тогтоолоор СЕХ-ны батлагдсан төсвөөс 6.6 тэрбум төгрөг, УИХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийн батлагдсан зардлаас хэмнэгдсэн төсвөөс 1.5 тэрбум, Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуулиар сум, дүүргийн ээлжит сонгуулийг зохион байгуулахаар аймаг, нийслэл, сум, дүүрэгт хуваарилсан зардлаас 5.8 тэрбум төгрөг, нийт 13.9 тэрбум төгрөгийг СЕХ-ны төсөвт төвлөрүүлэн Сум, дүүргийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийн зардлыг санхүүжүүлэхээр тогтоожээ.

УИХ-аас баталсан 13.9 тэрбум төгрөгийн төсвийг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороодод СЕХ-ны 2016 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын дагуу хуваарилан хүргүүлсэн байна.

Аймаг, нийслэлийн ИТХ-аас Сонгуулийн тухай хуулийн дагуу аймаг, нийслэлийн 22 сонгуулийн хороог байгуулан, сум, дүүргийн сонгуулийн хороодыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан ба сум, дүүргийн нийт 339 сонгуулийн хороо хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд сум, дүүргийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулсан байна.

Сум, дүүргийн ИТХ-ын 2016 оны сонгуулиар 2082 хэсэг, мэдээллийн технологийн 30 баг, тэдгээрт 20 мянга гаруй төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчид ажиллажээ.

¹ Сум, дүүргийн хурлын сонгуулийн тухайд сонгуулийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг сум, дүүргийн сонгуулийн хороо бие даан хэрэгжүүлнэ.

² Сум, дүүргийн хурлын сонгуулийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах аймаг, нийслэлийн сонгуулийн хороог энэ хуулийн 16.2-т заасан хугацаанаас 80 хоногийн өмнө аймаг, нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчид энэ хуульд нийцүүлэн байгуулна.

³ Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо сум, дүүргийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, нийт таваас есөн хүний бүрэлдэхүүнтэйгээр санал авах өдрөөс 65-аас доошгүй хоногийн өмнө байгуулна.

⁴ Сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг хүн амын тоог сонгуулийн нутаг дэвсгэртэй харьцуулан гаргасан сонгуулийн төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тухай бүр батална.

⁵ Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, орон нутгийн хурлын сонгуулийн доор дурдсан сонгуулийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.



БҮЛЭГ 1. СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХӨРӨНГИЙГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛАН ЗАРЦУУЛСАН БАЙНА

УИХ-ын 2016 оны 27 дугаар тогтоолоор сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулийг зохион байгуулахад зориулан 13,904.6 сая төгрөг зарцуулахыг СЕХ-нд зөвшөөрсний дагуу батлагдсан төсвийг СЕХ, аймаг, нийслэлийн сонгуулийн хороодод хуваарилсан байна.

Сонгуулийн зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл:

/сая.төг/

Нийт төсөв	Сонгуулийн ерөнхий хороо		Аймаг, нийслэл		Хэмнэлт, хэтрэлт
	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	
13,904.6	6,137.3	4,723.3	7,767.3	7,442.9	1,738.4

Нийт батлагдсан төсвийн 87.5 хувийг ээлжит сонгуулийг зохион байгуулахад зарцуулжээ.

2016 оны сонгуулийн санал өгөх насны иргэд, сонгуулийн хороодод ажиллах хүний тоо, төсвийн ерөнхий тоон мэдээллийн төлөвлөсөн дүнг 2012 онтой харьцуулан харуулбал дараахь байдалтай байна. Үүнд:

№	Үндсэн үзүүлэлт	Сум, дүүргийн ИТХ-ын 2012 оны сонгууль	Сум, дүүргийн ИТХ-ын 2016 оны сонгууль	Зөрүү
1	Сонгуулийн насны иргэний тоо	1,838,849	1,998,823	159,974
2	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны тоо	21	22	1
	Түүнд ажиллах хүний тоо /нэгж хэсэгт ажиллах хүний тоо/	147	238	91
3	Сум, дүүргийн сонгуулийн хорооны тоо	339	339	-
	Түүнд ажиллах хүний тоо /нэгж хэсэгт ажиллах хүний тоо/	2380	1979	(401)
4	Санал авах байрны тоо	2010	2082	72
5	Сонгуулийн санал авах байрт ажиллах нийт хүний тоо	13,440	13,035	(405)
6	Мэдээллийн технологийн багын тоо	30	30	-
7	Мэдээллийн технологийн багт ажиллах хүний тоо	141	139	(2)
8	Мэдээллийн технологийн даамлын тоо	2359	2455	96

Сонгуулийн насны хүн амын тооны өсөлт, Сонгуулийн хорооны санал авах байр, аймаг нийслэлийн нэгж хэсэгт ажиллах хүний тоо өсч, харин сум, дүүргийн нэгж хэсэгт ажиллах хүний тоо буурснаас сонгуулийн санал авах байранд ажилласан нийт хүний тоо буурсан байна.

Улсын төсвөөс гарах сонгуулийн зардал 2012 онд 5,036.9 сая төгрөг байсан бол 2016 онд 13,904.6 сая төгрөг болж 8,867.7 сая төгрөгөөр өссөн нь 2012 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад мөрдөгдөж байсан 2012 оны “Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль”-ийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4⁶-т заасан зарим зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг байсныг 2015 оны

⁶ Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ:....



“Сонгуулийн тухай хууль”-ийн 38 дугаар зүйлийн 38.2⁷ дахь заалтаар 100 хувь улсын төсвөөс санхүүжүүлэхээр хуульчилсантай холбоотой байна.

СЕХ нь сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлыг хангахаар 6,137.3 сая төгрөгийг дараах зориулалтаар зарцуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

/сая.төг/

№	Үзүүлэлт, зардлын агуулга	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Нэр дэвшигчийн үнэмлэх, сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагч болон сонгуулийн ажиглагчийн үнэмлэх хэвлэх, хүргүүлэх зардал /Хуулийн 38.2.2/	0.2	-	0.2
2	Саналын хуудас хэвлүүлэх, хамгаалах, хүргүүлэх зардал /Хуулийн 38.2.4/	3,195.6	3,014.6	180.9
3	Сонгуулийн дүн, мэдээний маягт, бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгогчийн гарын үсэг цуглуулах маягт, сонгуулийн байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудас хэвлэх, хүргүүлэх зардал /Хуулийн 38.2.5/	0.01	-	0.01
4	Тамга, тэмдэг, лац, саналын хуудас битүүмжлэн хадгалах уут бэлтгэх зардал /Хуулийн 38.2.6/	38.7	32.7	6.0
5	Санал авах, тоолох, дүн гаргах ажиллагаанд хэрэглэх техник, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, программ хангамж худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээ хийх, тээвэрлэх болон даатгал, тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл, тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хамгаалах, хадгалах, засвар үйлчилгээ хийх, хэвлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хүргэх, татан авах зардал /Хуулийн 38.2.7/	1,660.6	1,159.8	500.8
6	Санал хураалтын дүнгийн мэдээ дамжуулах зардал /Хуулийн 38.2.8/	157.0	48.8	108.2
7	Саналын хайрцаг хийх, хүргэх, санал авах байрын болон санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал /Хуулийн 38.2.9/	20.1	-	20.1
8	Сонгуулийн хууль тогтоомж болон сонгууль зохион байгуулахтай холбогдсон эрх зүйн бусад акт, гарын авлага, сургалт, сурталчилгааны материал боловсруулах, хэвлэх, хүргэх зардал /Хуулийн 38.2.10/	326.5	265.4	61.0
9	Сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал /Хуулийн 38.2.11/	144.3	10.6	133.7
10	Сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах болон сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээний зардал /Хуулийн 38.2.12/	181.5	67.5	114.0
11	Сонгуульд нэр дэвшүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, зарцуулалтыг хянан шалгахад гарах зардал /Хуулийн 38.2.13/	8.0	-	8.0
12	Сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн болон ажлын хэсгийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал /Хуулийн 38.2.15/	28.1	9.6	18.5

⁷ Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, орон нутгийн хурлын сонгуулийн доор дурдсан сонгуулийн зардлыг **улсын төсвөөс санхүүжүүлнэ**:...



13	Сонгуулийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал /Хуулийн 38.2.16/	55.9	18.5	37.3
14	Сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны зардал /Хуулийн 38.2.1/	95.5	48.6	46.9
ДҮН		5,912.0	4,676.2	1,235.6
15	Дахин болон нэмэлт санал хураах, ээлжит бус болон дахин сонгууль явуулах болон онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал /Хуулийн 38.2.14, 38.2.18/	225.3	47.1	178.3
НИЙТ ДҮН		6,137.3	4,723.3	1,414.0

СЕХ нэрсийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоог үндэслэн “Мөнхийн үсэг групп” ХХК-тай 2016 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн ОНС-18 тоот гэрээ байгуулан нийт 1,093,506 ширхэг саналын хуудсыг 1,630.0 сая төгрөг, “Таван богд менежмент” ХХК-тай 2016 оны 10 дугаар сарын 3-ны өдөр ОНС-23\25\215 тоот гэрээ байгуулан 929,630 ширхэг саналын хуудсыг 1,329.3 сая, “Адмон принт” ХХК-тай ОНС-21 тоот гэрээ байгуулан 55.3 сая төгрөгөөр бусад материалыг тус тус хэвлүүлжээ.

Дээрх сонгуулийн саналын хуудсыг хэвлүүлэх худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.7⁸-д заасны дагуу зохион байгуулсан байна.

Сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийг явуулахад улсын төсвөөс олгосон 7,767.3 сая төгрөгийн санхүүжилтээс сум, дүүргийн Сонгуулийн хороод 7,442.9 сая төгрөг буюу 95.8 хувийг зарцуулж, үлдэгдэл 324.3 сая төгрөгийг СЕХ-ны Төв төрийн сан дахь 900022001 тоот дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Сум, дүүргийн Сонгуулийн хорооны батлагдсан төсөв, зарцуулалтыг хүснэгтээр үзүүлбэл:

/сая.төг/

№	Сум, дүүргийн Сонгуулийн хороо	Сум, дүүргийн сонгуулийн хороо	Хэсгийн тоо	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Буцаан төвлөрүүлсэн
1	Архангай	19	104	382.0	377.5	4.5
2	Баян-Өлгий	13	90	317.4	309.4	8.0
3	Баянхонгор	20	106	396.5	385.8	10.7
4	Булган	16	75	303.5	293.0	10.4
5	Говь-Алтай	18	87	358.2	323.3	34.9
6	Говьсүмбэр	3	10	53.5	51.7	1.8
7	Дорноговь	14	70	269.8	255.2	14.6
8	Дорнод	14	73	263.6	263.6	0.0
9	Дундговь	15	66	258.7	236.0	22.7
10	Завхан	24	115	461.4	452.9	8.5
11	Өвөрхангай	19	112	397.9	396.3	1.6
12	Өмнөговь	15	59	250.3	249.0	1.3
13	Сүхбаатар	13	67	247.2	233.3	13.9
14	Сэлэнгэ	17	68	290.1	277.3	12.8
15	Төв	27	98	421.6	371.7	49.9
16	Увс	19	93	327.9	297.8	30.1
17	Ховд	17	91	359.5	359.5	0.0
18	Хөвсгөл	23	127	483.9	469.3	14.6
19	Хэнтий	18	91	319.3	313.6	5.8

⁸ Сонгуулийн төв байгууллагаас Сонгуулийн тухай хуулийн 38.1-д заасан төсвийн хүрээнд сонгууль зохион байгуулахтай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.



20	Дархан-Уул	4	39	151.0	145.4	5.6
21	Орхон	2	43	155.4	153.5	1.9
22	Нийслэл	9	398	1,298.7	1,227.8	70.9
Нийт дүн		339	2082	7,767.3	7,442.9	324.4

СЕХ сонгуулийн зардлыг хуваарилахдаа сонгогчийн тоо, газар нутгийн хэмжээ, байршил, сум, дүүргийн сонгуулийн хорооны тоо, санал авах байрны тоо, тэдгээрт ажиллах сонгуулийн хорооны гишүүн, зохион байгуулагч, мэдээллийн технологийн ажилтны тоо, нэр дэвшигчийн тоо зэргийг харгалзан хуваарилжээ.

Хуваарилсан зардлын гүйцэтгэлийг зардлын ангиллаар харуулбал: /сая.төг/

№	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	7.7	6.8	0.9
2	Төрөл бүрийн үнэмлэх хэвлэх зардал	58.0	55.7	2.3
3	Сургалтын зардал	270.7	249.2	21.5
4	Бичиг хэргийн зардал	256.5	253.6	2.9
5	Шуудан холбооны зардал	258.7	255.0	3.7
6	Унааны зардал	927.2	888.6	38.6
7	Хууль тогтоомж сурталчилах зардал	211.2	179.5	31.7
8	Санал авах байр бэлтгэх зардал	410.4	399.3	11.1
9	МТБ-ийн мэдээ дамжуулах зардал	15.5	14.5	1.0
10	Томилолтын зардал	122.2	108.6	13.6
11	Саналын хуудас авах зардал	114.6	90.5	24.1
12	ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх	287.1	243.5	43.6
13	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	96.3	90.4	5.9
14	Болзошгүй зардал	152.8	132.9	19.9
15	Сурталчилгааны материал хүргэх зардал	36.6	32.4	4.2
16	Сонгуулийн байгууллагын ажилтан сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	3,849.1	3,751.9	97.3
17	МТБ-ийн гишүүн, даамлын сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	692.6	690.5	2.1
ДҮН		7,767.3	7,442.9	324.4

Сонгуулийн байгууллагын ажилтанд олгох мөнгөн урамшуулал, хоолны зардал, ICP машин, сурталчилгаа зэрэг зардлын гүйцэтгэлээс шалтгаалан нийт зардал 4.3 хувь буюу 324.4 сая төгрөгөөр хэмнэгджээ.



БҮЛЭГ 2. ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВЬЖ БУЙ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС АНХАН ШАТНЫ БАРИМТГҮЙ ГҮЙЛГЭЭ ХИЙСЭН, ЗАРДАЛ ХООРОНД ШИЛЖҮҮЛСЭН ЗӨРЧИЛ ГАРГАСАН БАЙНА

Сум, дүүргийн сонгуулийн зардлыг батлагдсан хэмжээнд зарцуулсан хэдий ч зарим аймагт анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад гүйлгээ хийсэн, зохих шатны байгууллагын зөвшөөрөлгүйгээр зардал хооронд шилжүүлсэн, зориулалт бусаар зарцуулсан зөрчил гаргасан байна. Тухайлбал:

- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Сонгуулийн хороо 3.2 сая, Баянгол 1.6 сая, Сүхбаатар 1.4 сая, Багануур 0.8 сая, Сонгинохайрхан 0.5 сая, нийт 7.5 сая төгрөгийн гүйлгээг НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4⁹, СЕХ-ны 2016 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4.1¹⁰ дэх заалтыг тус тус зөрчин анхан шатны баримтгүйгээр болон бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн;
- Нийслэлийн Сонгинохайрхан 1.6 сая, Сүхбаатар 1.0 сая, Баянгол 0.5 сая, Багахангай дүүргийн Сонгуулийн хороо 0.2 сая, нийт 3.3 сая төгрөгийг СЕХ-ны 2016 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.2¹¹-т заасныг зөрчин Нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэргүйгээр зардал хооронд гүйлгэн зарцуулснаас шалтгаалан сонгуулийн зардлын нэгдсэн гүйцэтгэлээр бусад зардал буюу эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал батлагдсан төсвөөс 2.7 сая төгрөгөөр хэтэрсэн;
- Нийслэлийн Сонгуулийн хорооны 2016 оны 38 тоот албан бичгийн 1 дүгээр хавсралтын 5 дугаар зүйлд “сонгуулийн байгууллагын ажилтны хоолны зардалд 1 хүнд 50.0 мянган төгрөг”, 6 дугаар зүйлд “санал авах байрны даамлын хоолны зардалд 1 хүнд 30.0 мянган төгрөг” олгохоор заасныг зөрчин Сүхбаатар дүүргийн Сонгуулийн хороо 954.0 мянга, Сонгинохайрхан дүүргийн Сонгуулийн хороо 45.0 мянга, нийт 999.0 мянган төгрөгийн хоолны зардлыг мэдээлэл технологийн ажилтан, зохион байгуулагч нарт илүү олгосон;
- Нийслэлийн Багануур дүүргийн Сонгуулийн хороо Төсвийн тухай хуулийн 16.5.5¹², Сонгуулийн тухай хуулийн 34.1.6¹³-д заасныг зөрчин дүүргийн ИТХ-ын сонгуулийн зардалд хамаарахгүй шуудан холбооны зардлын 44.6 мянган төгрөгийг төлж зориулалт бусаар зарцуулсан;
- Булган аймгийн хэмжээнд 20.7 сая төгрөгийн зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6¹⁴ дахь заалтыг зөрчсөн, Баян-Агт сумын Сонгуулийн хорооны ажилтны хувийн данс руу дөрвөн удаа 12.5 сая, Сэлэнгэ сумын Сонгуулийн хорооны няравын хувийн харилцахаар 3 удаа 1.1 сая төгрөгийн гүйлгээ тус тус хийсэн нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.3¹⁵ дахь заалттай нийцээгүй;
- Говь-Алтай аймгийн Сонгуулийн хороо хоолны зардлаас зориулалт бусаар 0.3 сая төгрөг зарцуулсан, Сонгуулийн хорооны гишүүдэд томилолтын зардал 0.2 сая төгрөг, сумын сонгуулийн хорооны ажилтанд 3.6 сая төгрөгийн хоолны зардлыг тус тус илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹⁶ дэх заалтыг зөрчсөн, жолоочийн замын хуудасгүй 10.9 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан, анхан шатны баримтгүйгээр 0.3 сая

⁹ Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх

¹⁰ Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтлөнө

¹¹ Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ

¹² “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”

¹³ улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих

¹⁴ “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”

¹⁵ “Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн 300,000 төгрөг, тээвэр шатахууны хэмжээ 500,000 төгрөгөөс хэтрэхгүй байна”

¹⁶ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;



төгрөгийг зарцуулсан, хувь хүний нэрийн дансаар 0.3 сая төгрөгийн татвар суутган тооцолгүй шилжүүлсэн нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7¹⁷ дахь заалтыг зөрчсөн;

- Говь-Алтай аймгийн Сонгуулийн хороо үйл ажиллагаанд зарцуулахаар бэлтгэсэн цаашид ашиглах боломжтой 6.5 сая төгрөгийн бараа материалыг шууд зардалд бичсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2¹⁸ дахь заалт, Хөхморьт сумын төрийн сангийн төлөөлөгч нь анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, хүчин төгөлдөр бус баримтаар 1.5 сая төгрөгийн /тамга, тэмдэггүй/ гүйлгээг хийсэн нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6¹⁹ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Аудитын явцад аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороод ИТХ-ын сонгууль зохион байгуулах зардлыг холбогдох хууль, заавар журмын дагуу зарцуулаагүй зөрчлийг арилгуулахаар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар 1.12²⁰-т заасны дагуу төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөнийг хүснэгтээр үзүүлбэл:

/сая.төг/

№	Сум, дүүргийн Сонгуулийн хороо	Акт	Албан шаардлага	Зөрчлийн агуулга
1	Булган	-	1.3	Анхан шатны баримтгүй
2	Говь-Алтай	0.6	15.7	Зориулалт бусаар зарцуулсан, батлагдсан нормоос хэтрүүлсэн, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ, суутгал хийгээгүй ажил, гүйлгээ бүртгэсэн
3	Дорноговь	-	0.8	Зарцуулагдаагүй үлдэгдэл
4	Дундговь	-	0.6	Батлагдсан төсвийг зардлын зүйл, анги шилжүүлэн зарцуулсан
5	Өвөрхангай	-	1.4	Хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй
6	Өмнөговь	0.1	22.7	Батлагдсан төсвийг зардлын зүйл, анги шилжүүлэн зарцуулсан, анхан шатны баримтгүй зарцуулсан, бэлтгэсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй
7	Сэлэнгэ	-	21.2	Анхан шатны баримтын бүрдэл дутуу
8	Ховд	1.3	22.8	Батлагдсан төсвийг зардлын зүйл, анги шилжүүлэн зарцуулсан, анхан шатны баримтгүй зарцуулсан, зардал давхардуулан олгосон.
9	Дархан-Уул	0.2	-	Орлогыг бүртгэлд авч тусгаагүй
	Нийт дүн	2.2	86.5	

Аймаг, нийслэлийн Сонгуулийн хороод холбогдох журам, зааврын дагуу баримт, материалыг архивт шилжүүлсэн байна.

¹⁷ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

¹⁸ санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;

¹⁹ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

²⁰ аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих;



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛС
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж 11, Засгийн газрын XI байр,
Утас: 26-09-75, Факс: (976-11) 32-69-75,
E-mail: gecm@gec.gov.mn, http://www.gec.gov.mn

2017.02.09-ны 30
танай _____-ны № 2/165 -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн зардалд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд тусгайлан өгөх саналгүй байна.

ДАРГА  Ч.СОДНОМЦЭРЭН



000038



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- Сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу хуваарилан зарцуулсан байна.
- Хөрөнгийн зарцуулалтад тавьж буй хяналт хангалтгүйгээс анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, зардал хооронд шилжүүлсэн зөрчил гаргасан байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргад:

- Сонгуулийн хороодын батлагдсан төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.4.7, “Нийцлийн аудитын түр журам”-ын 9.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Сонгуулийн Ерөнхий Хороонд тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 05 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сонгуулийн Ерөнхий Хорооны дарга /Ч.Содномцэрэн/-д зөвлөсүгэй.
4. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газрын дарга /Б.Алтанзул/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР



Хавсралт №1

Сум, дүүргийн ИТХ-ын 2016 оны сонгуулийн зардлыг аймаг, нийслэлийн сонгуулийн хороогоор хуваарилсан товчоо

Аймаг, нийслэлийн нэр	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны тоо	Сум, дүүргийн сонгуулийн хороо	Хэсгийн тоо	Мянгт хэвлэх зардал	Үнэмлэх хэвлэх зардал	Сонгуулийн хорооны суртал	Гэрчилгээжүүлэх суртал	МТБ, даамлын суртал	Бичиг хэргийн зардал	Шүүдэн холбооны зардал	Үнаны зардал	Сурталчилгааны зардал	Санал авах байр бэлтгэх зардал	МТБ-ийн мэдээ дамжуулах зардал	Томилголын зардал	Саналын хуудсыг хүргэх зардал	Санал тоолох төхөөрөмж хүргэх, татан авах зардал	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	Бонзшуй зардал	Сурталчилгааны материал хүргэх зардал	Сонгуулийн байгууллагын ажиглалтын урамшуулал, хоолны зардал	МТБ болон даамлын урамшуулал, хоолны зардал	Бичиг хэргийн ажиглалт, нягтлалтын урамшуулал, хоолны зардал	НИЙТ ДҮН	
																									/МЯН.ТӨГ/
1	Архангай	1	19	104	350	1,900	4,848	-	9,308	12,620	12,620	50,500	8,000	20,800	600	5,894	6,487	17,428	5,096	3,000	2,050	185,636	33,957	900	381,993
2	Баян-Өлгий	1	13	90	350	1,300	3,264	2,065	7,344	10,300	10,300	42,250	8,000	18,000	600	7,651	3,946	13,692	4,410	3,000	1,450	149,792	28,749	900	317,363
3	Баянхонгор	1	20	106	350	2,000	5,112	-	9,776	12,980	12,980	51,750	8,000	21,200	600	6,582	6,955	18,158	5,194	3,000	2,150	194,093	34,738	900	396,519
4	Булган	1	16	75	350	1,600	4,056	2,891	7,242	9,700	9,700	38,125	8,000	15,000	600	4,850	5,423	12,350	3,675	2,500	1,750	149,112	25,624	900	303,448
5	Говь-Алтай	1	18	87	350	1,800	4,584	-	8,258	11,060	11,060	43,625	8,000	17,400	600	7,675	6,739	17,310	4,263	2,500	1,950	180,814	29,270	900	358,158
6	Говьсүмбэр	1	3	10	350	300	624	-	652	1,900	1,900	6,250	3,000	2,000	360	1,846	1,319	2,234	490	1,000	450	23,370	4,542	900	53,487
7	Дорноговь	1	14	70	350	1,400	3,528	3,717	6,344	8,900	8,900	35,250	8,000	14,000	600	4,764	4,917	11,126	3,430	2,500	1,550	125,842	23,802	900	269,820
8	Дорнод	1	14	73	350	1,400	3,528	-	6,966	9,140	9,140	36,625	8,000	14,600	600	5,390	5,132	14,474	3,577	2,800	1,550	115,276	24,983	900	263,630
9	Дундговь	1	15	66	350	1,500	3,792	5,782	6,368	8,780	8,780	34,250	8,000	13,200	600	4,452	5,050	9,354	3,234	2,500	1,650	117,180	23,020	900	258,742
10	Завхан	1	24	115	350	2,400	6,168	-	11,034	14,530	14,530	57,225	8,000	23,050	600	9,225	7,334	18,961	5,685	5,070	2,550	235,663	38,124	900	461,399
11	Өвөрхангай	1	19	112	350	1,900	4,848	3,717	9,916	13,260	13,260	53,500	8,000	22,400	600	5,764	6,438	17,332	5,488	4,000	2,050	188,143	36,040	900	397,907
12	Өмнөговь	1	15	59	350	1,500	3,792	-	5,962	8,220	8,220	31,625	8,000	11,800	600	5,347	5,350	10,786	2,891	2,000	1,650	120,089	21,198	900	250,279
13	Сүхбаатар	1	13	67	350	1,300	3,264	2,478	6,010	8,460	8,460	33,625	8,000	13,400	600	4,906	4,724	11,472	3,283	2,500	1,450	109,225	22,760	900	247,167
14	Сэлэнгэ	1	17	68	350	1,700	4,320	3,304	7,044	9,340	9,340	36,000	8,000	13,600	600	4,998	5,712	10,852	3,332	2,500	1,850	142,263	24,062	900	290,067
15	Төв	1	27	98	350	2,700	6,960	4,956	10,720	13,740	13,740	52,250	8,000	19,600	600	6,258	8,521	13,966	4,802	3,000	2,850	213,234	34,478	900	421,625
16	Увс	1	19	93	350	1,900	4,848	-	8,622	11,740	11,740	46,375	8,000	18,600	600	8,760	5,794	14,757	4,557	3,000	2,050	144,207	31,093	900	327,892
17	Хөвд	1	17	91	350	1,700	4,320	-	8,032	11,350	11,350	45,225	8,000	18,200	600	8,419	5,178	16,267	4,739	3,100	1,850	179,689	30,051	900	359,521
18	Хөвсгөл	1	23	127	350	2,300	5,904	2,478	11,618	15,260	15,260	61,375	8,000	25,400	600	7,659	8,019	24,296	6,223	6,125	2,450	238,654	40,988	900	483,859
19	Хэнтий	1	18	91	350	1,800	4,584	-	7,894	11,380	11,380	45,125	8,000	18,200	600	5,266	6,039	14,880	4,459	5,000	1,950	141,214	30,312	900	319,333
20	Дархан-Уул	1	4	39	350	400	898	-	1,170	4,420	4,420	18,625	8,000	7,800	600	1,994	1,646	3,876	1,911	2,000	550	77,819	13,646	900	151,015
21	Орхон	1	2	43	350	200	360	-	1,064	4,340	4,340	19,125	8,000	8,600	600	2,043	1,159	3,701	2,107	2,000	350	81,714	14,427	900	155,381
22	Нийслэл	1	9	398	350	3,000	3,318	-	5,065	41,100	45,650	92,615	45,000	79,600	2,520	900	2,610	17,560	13,118	93,052	-	716,777	127,416	9,000	1,298,651
НИЙТ ДҮН		22	339	2,082	7,700	36,000	86,910	31,388	156,009	252,520	257,070	931,315	208,000	416,450	15,080	120,643	114,492	294,831	95,964	156,147	36,150	3,829,805	692,880	27,900	7,767,255



Хавсралт №2

Сум, дүүргийн ИТХ-ын 2016 оны сонгуулийн аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл

/МЯН.ТӨГ/

№	Аймаг, нийслэлийн нэр	Төсөв	Маягт хөвөх зардал	Төрөл бүрийн үнэмлэх хөвөх зардал	Сурталчлал зардал	Бичиг хэргийн зардал	Шуудан холбоо	Унааны зардал	Сурталчлал зардал	Санал авах байр болгох зардал	МТБ-ийн мэдээ дамжуулах зардал	Томилогч зардал	Саналын худас хүргэх зардал	ИСР машиныг хүлээн авах, хүлээн өгөх	САС-ийн зардал /эрич хүчний эх үүсвэр/	Боловсрол зардал	Сурталчлал материалын хургах зардал	Сонгуулийн байгууллагын ажилгын урамшуулал	МТБ, даамлын урамшуулал, хөвөл	Гүйцэтгэл ИЙН ДҮН
1	Архангай	381,993	345	2,459	14,153	13,239	12,593	49,518	13,000	20,967	600	6,130	6,159	11,830	5,096	2,500	2,050	183,185	33,697	377,521
2	Баян-Өлгий	317,363	350	1,300	11,523	10,300	10,300	40,091	8,000	18,000	600	6,971	3,746	11,934	4,410	1,000	1,450	150,692	28,749	309,416
3	Баянхонгор	396,519	350	3,110	14,083	12,973	10,901	51,750	7,750	21,200	600	5,668	3,627	16,314	5,194	3,000	1,110	194,993	33,176	385,799
4	Булган	303,448	350	1,600	11,314	10,011	10,458	35,792	7,720	14,792	600	5,009	5,008	7,326	3,616	1,627	1,533	150,888	25,394	293,038
5	Говь-Алтай	358,158	350	1,737	12,376	11,438	11,605	43,477	7,274	15,859	300	7,199	3,569	16,552	4,560	1,031	1,450	155,471	29,010	323,257
6	Говьсүмбэр	53,487	350	300	1,276	1,900	1,900	6,250	3,000	2,000	360	1,202	1,235	1,780	490	375	450	24,270	4,542	51,679
7	Дорноговь	269,820	350	2,447	10,639	8,901	8,901	35,753	6,958	14,018	600	4,145	1,460	8,329	3,291	1,983	1,549	122,102	23,802	255,227
8	Дорнод	263,630	350	1,400	10,094	9,160	9,165	36,625	8,000	14,600	600	5,345	5,132	14,474	3,577	2,800	1,550	116,176	24,583	263,630
9	Дундговь	258,742	20	1,209	8,198	8,767	8,725	33,920	7,507	13,200	598	4,129	2,292	6,284	3,233	1,384	1,460	112,064	23,020	236,020
10	Завхан	461,399	350	3,240	17,202	14,730	13,890	57,975	8,000	23,050	850	9,225	7,334	19,961	5,885	5,545	2,550	224,992	38,124	452,902
11	Өвөрхангай	397,907	162	2,312	18,322	13,340	13,365	54,003	8,499	22,398	750	5,644	6,420	17,204	5,608	4,135	2,046	186,309	35,780	396,298
12	Өмнөговь	250,279	350	1,450	9,754	8,197	8,220	31,625	7,905	11,798	600	4,076	5,350	10,367	2,891	1,730	1,425	122,057	21,198	248,993
13	Субаатар	247,167	224	1,300	11,060	8,961	8,429	31,761	3,612	13,295	600	3,832	3,000	8,777	2,403	1,770	1,350	110,175	22,760	233,309
14	Сэлэнгэ	290,067	337	1,680	14,325	9,398	8,912	36,300	8,000	6,800	592	3,665	1,861	9,055	3,360	2,200	1,752	144,983	24,062	277,280
15	Төв	421,625	350	2,323	16,638	13,892	14,205	48,322	5,150	19,862	170	4,411	6,928	1,238	1,650	-	1,500	201,132	33,957	371,726
16	Увс	327,892	350	8,315	13,428	11,421	11,010	18,871	5,318	18,210	320	7,179	4,519	14,407	4,237	1,421	1,640	146,036	31,093	297,776
17	Ховд	359,521	350	1,700	12,352	11,350	11,350	45,225	8,000	18,200	800	8,419	5,178	16,267	4,739	3,100	1,850	180,589	30,051	359,521
18	Хөвсгөл	483,859	350	2,300	20,000	15,357	15,860	56,337	8,010	23,501	600	7,657	8,019	17,669	6,042	3,926	2,882	239,763	40,988	469,262
19	Хэнтий	319,333	350	1,800	12,174	11,360	11,299	44,731	8,000	18,060	600	4,349	5,286	11,595	3,988	5,145	1,950	142,588	30,312	313,585
20	Дархан-Уул	151,015	118	551	839	4,420	4,420	18,625	8,000	7,798	600	1,872	941	2,729	-	-	531	80,339	13,646	145,428
21	Орхон	155,381	336	198	1,407	4,340	4,340	19,125	7,680	8,600	600	1,604	1,159	3,002	2,107	366	350	83,819	14,427	153,460
22	Нийслэл	1,298,651	342	12,958	8,042	40,156	45,111	92,486	24,130	73,045	2,519	900	2,360	16,412	14,041	87,875	-	679,266	128,118	1,227,760
НИЙТ ДҮН		7,767,255	6,783	55,689	249,197	253,608	254,959	888,563	179,513	399,251	14,459	108,631	90,582	243,507	90,417	132,924	32,427	3,751,889	690,487	7,442,886



СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН 2016 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

/мянган төгрөг/

№	ҮЗҮҮЛЭЛТ, ЗАРДЛЫН АГУУЛГА	ТӨСӨВ	ГҮЙЦЭТГЭЛ	ҮЛДЭГДЭЛ
1	Нэр дэвшигчийн үнэмлэх, сонгуулийн штабын ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагч болон сонгуулийн ажиглагчийн үнэмлэх хэвлэх, хүргүүлэх зардал /Хуулийн 38.2.2/	183.5	0.00	183.5
2	Саналын хуудас хэвлүүлэх, хамгаалах, хүргүүлэх зардал /Хуулийн 38.2.4/	3,195,585.9	3,014,612.7	180,973.3
3	Сонгуулийн дүн, мэдээний маягт, бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгогчийн гарын үсэг цуглуулах маягт, сонгуулийн байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудас хэвлэх, хүргүүлэх зардал /Хуулийн 38.2.5/	6.2	0.00	6.2
4	Тамга, тэмдэг, лац, саналын хуудас битүүмжлэн хадгалах уут бэлтгэх зардал /Хуулийн 38.2.6/	38,720.0	32,732.00	5,988.0
5	Санал авах, тоолох, дүн гаргах ажиллагаанд хэрэглэх техник, тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл, программ хангамж худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээ хийх, тээвэрлэх болон даатгал, тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл, тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хамгаалах, хадгалах, засвар үйлчилгээ хийх, хэвлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хүргэх, татан авах зардал /Хуулийн 38.2.7/	1,660,562.8	1,159,761.2	500,801.6
6	Санал хураалтын дүнгийн мэдээ дамжуулах зардал /Хуулийн 38.2.8/	157,040.0	48,831.6	108,208.4
7	Саналын хайрцаг хийх, хүргэх, санал авах байрын болон санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал /Хуулийн 38.2.9/	20,062.6	0.00	20,062.6
8	Сонгуулийн хууль тогтоомж болон сонгууль зохион байгуулахтай холбогдсон эрх зүйн бусад акт, гарын авлага, сургалт, сурталчилгааны материал боловсруулах, хэвлэх, хүргэх зардал /Хуулийн 38.2.10/	326,462.2	265,434.1	61,028.1
9	Сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал /Хуулийн 38.2.11/	144,331.6	10,644.00	133,687.6
10	Сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах болон сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээний зардал /Хуулийн 38.2.12/	181,498.6	67,527.5	113,971.1
11	Сонгуульд нэр дэвшүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, зарцуулалтыг хянан шалгахад гарах зардал /Хуулийн 38.2.13/	8,000.0	0.00	8,000.00
12	Сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн болон ажлын хэсгийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал /Хуулийн 38.2.15/	28,076.3	9,605.0	18,471.3
13	Сонгуулийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал /Хуулийн 38.2.16/	55,872.5	18,542.6	37,329.9
14	Сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны зардал /Хуулийн 38.2.1/	95,500.0	48,558.9	46,941.1
ДҮН		5,911,902.3	4,676,249.5	1,235,652.8
15	Дахин болон нэмэлт санал хураах, ээлжит бус болон дахин сонгууль явуулах болон онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал /Хуулийн 38.2.14, 38.2.18/	225,444.3	47,072.7	178,371.5
НИЙТ ДҮН		6,137,346.6	4,723,322.2	1,414,024.3